

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын 2011 оны *т.б.дугаар* сарын *09* өдрийн *хорин нэгдүгээр* тушаалын нэгдүгээр хавсралт



УРАН САЙХНЫ ГИМНАСТИКИЙН ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Нийт дүн
1.	Тамирчдын шагнал: 1-р байр: 8 x 10000 төг = 80000 төгрөг 2-р байр: 8 x 8000 төг = 64000 төгрөг 3-р байр: 8 x 6000 төг = 48000 төгрөг	192.000
2.	Шүүгчдийн ажлын хөлс: /12 хүн x 2 өдөр x 15.000 төг/	360.000
3.	Медалийн үнэ:	135.000
<b>ДҮН:</b>		<b>687.000 төг</b>

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын  
даргын 2011 оны *Төвдүүлэлт* сарын 09 өдрийн  
*хорин нэгдүгээр* тушаалын хоёрдугаар хавсралт



УРАН САЙХНЫ ГИМНАСТИКИЙН  
ТЭМЦЭЭНИЙ ШҮҮГЧДИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН

№	Шүүгчдийн овог, нэр	Байгууллага	Гүйцэтгэх үүрэг	Зэрэг
1.	Б.Бат-Отгон	МГХ	Ерөнхий шүүгч	УШ
2.	Б.Халиун	МГХ	Нарийн бичиг шүүгч	УШ
3.	Ш.Оюунчимэг	МГХ	Шүүгч	УШ
4.	Х.Үржинсүрэн	МГХ	Шүүгч	УШ
5.	Н.Хүрлээ	МГХ	Шүүгч	УШ
6.	Ж.Цэрэндулам	МГХ	Шүүгч	УШ
7.	Ч.Отгонцэцэг	МГХ	Шүүгч	УШ
8.	Д.Хишгээ	МГХ	Шүүгч	УШ
9.	Б.Булган	МГХ	Шүүгч	УШ
10.	Т.Батбагана	МГХ	Шүүгч	УШ
11.	Б.Ичинхорлоо	МГХ	Шүүгч	УШ
12.	Б.Оюун	МГХ	Шүүгч	УШ

БАТЛАВ.  
НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР,  
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА  
Ж. ГАНБОЛД

УЛААНБААТАР ХОТЫН 2011 ОНЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
УРАН САЙХНЫ ГИМНАСТИКИЙН ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

**Нэг. Тэмцээний зорилго:**

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 246, 2009 оны 05 дугаар тогтоолууд, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Уран сайхны гимнастикийн спортыг нийтийн хүртээл болгох, спортын ур чадварыг дээшлүүлэх, хичээллэгчдийн хүрээг өргөжүүлэн, уран сайхны гимнастикийн шигшээ багийн залгамж халааг бэлтгэж гаргах, шилдэг тамирчдыг шалгаруулахад тэмцээний гол зорилго оршино.

**Хоёр. Тэмцээн явуулах хугацаа, газар:**

Улаанбаатар хотын аварга шалгаруулах Уран сайхны гимнастикийн тэмцээнийг 2011 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Гимнастикийн төв зааланд зохион байгуулна. Тэмцээнд уран сайхны гимнастикийн спортоор хичээллэж байгаа бүх тамирчид зэргийн ангиллаар оролцоно.

**Гурав. Тэмцээн явуулах журам:**

Тэмцээнийг 8 зэргийн ангилалаар зохион байгуулна. Тэмцээн Олон улсын дүрмийн шүүлтийн дагуу явагдана. Үүнд:

СМ: - цагираг, бөмбөг, булав, тууз	12 хүндрэл
СДМ: - цагираг, бөмбөг, булав, тууз	10-12 хүндрэл
Өсвөрийн 1-р зэрэг: - цагираг, бөмбөг, булаав, тууз (D2)	10 хүндрэл
Өсвөрийн 2-р зэрэг: - чөлөөт, цагираг, бөмбөг, булаав (D2)	8 хүндрэл
Өсвөрийн 3-р зэрэг: - чөлөөт, олс, цагираг, бөмбөг (D2)	8 хүндрэл
Охидын 3 хэрэглэл: - чөлөөт 8 хүндрэл, олс, цагираг (D2)	6 хүндрэл
Охидын 2 хэрэглэл: - чөлөөт 4 хүндрэл, олс	6 хүндрэл
Охидын 1 хэрэглэл: - хэрэглэлгүй хийх дасгал	4 хүндрэл

**Дөрөв. Тэмцээнийг дүгнэх журам:**

Тэмцээнийг Олон улсын дүрмийн дагуу 30 баллын үнэлгээнээс шүүж, эхний 1, 2, 3-р байрыг шалгаруулж медаль, диплом, мөнгөн шагналаар шагнана. Дасгалжуулагчийн дүнг тамирчдын амжилтаар дүгнэн гаргана.

**Тав. Техникийн зөвлөгөөн:**

Техникийн зөвлөгөөнийг 05 дугаар сарын 18-нд 17.00 цагт Нийслэлийн нутгийн захиргааны “Хангарьд” ордны 509 тоот Биеийн тамир, спортын газрын байранд зохион байгуулна. Техникийн зөвлөгөөнд ирэхдээ тамирчдын мэдүүлэг, 1 хувь зураг, төрсний гэрчилгээ /хуулбарын хамт/, эрүүл мэндийн дэвтэр /хуулбарын хамт/, танилцуулга, элементийн хүндрэлийн хүснэгт зэрэг материалыг бүрдүүлж ирнэ.

Шүүгч нарын семинарыг 05-р сарын 11-ний 18:00 цагт Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын 110 тоот өрөөнд явуулна.



66

## НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 1/21

Улаанбаатар хот

### Уран сайхны гимнастикийн тэмцээн зохион байгуулах тухай

Монгол улсын Биеийн тамир, спортын тухай хууль, Засгийн газрын 2005 оны 246, 2009 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 17.1.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2009-2012 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

Нэг. Улаанбаатар хотын 2011 оны аварга шалгаруулах Уран сайхны гимнастикийн тэмцээнийг 2011 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Гимнастикийн төв зааланд зохион байгуулсугай.

Хоёр. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 687.000 /зургаан зуун наян долоон мянга/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын спортын арга хэмжээний зардлаас гаргахыг ня-бо Ж.Цэдэнсодномд зөвшөөрсүгэй.

Дөрөв. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг нийтийн биеийн тамирын бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн О.Болор-Эрдэнэд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД